



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот


Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, “Жендэрийн үндэсний хорооны бүрэлдэхүүн, дүрэм, ажлын албаны орон тоог батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 323 дугаар тогтоолын 6.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Барилга, хот байгуулалтын салбарт жендэрийн талаар баримтлах бодлогын баримт бичигт тулгуурлан жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, шаардагдах зардлыг төсөвт тусган хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах ажиллахыг Жендэрийн орон тооны бус салбар зөвлөл /С.Магнайсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 109 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.


Х.БАДЕЛХАН

151010100

Барилга, хот байгуулалтын сайдын
2020 оны 02 дугаар сарын 07 ны
өдрийн 34 тушаалын хавсралт

Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх
Жендэрийн орон тооны бус салбар зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга:

Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн

Гишүүд:

- Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Баярсайхан;
- Барилга, хот байгуулалтын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Баярбат;
- Барилга, хот байгуулалтын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Н.Нарантуяа;
- “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Т.Нямдаваа;
- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн С.Ганцэцэг;
- “Монголын Барилгын зураг төсөл зохиогчдын холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Гантулга;
- “Монголын Барилгын үндэсний ассоциаци” ТББ-ын дэргэдэх Барилгын үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн хэлтсийн захиргааны мэргэжилтэн М.Энхтуул;
- “Монголын Бүтээгч барилгачин эмэгтэйчүүдийн холбоо” ТББ-ын тэргүүн Ш.Хүрэлтогоо;
- “Монголын барилгын гүйцэтгэгч байгууллагуудын холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал А.Байгалмаа;
- “Монголын Дэд бүтэц, зам тээвэр, барилга, хот байгуулалтын салбарын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг” ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн, Хэрэглэгчийн удирдлагын Академийн захирал Г.Замбага.

Нарийн бичгийн дарга:

- Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Салбарын сургалт, хүний нөөцийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч /Жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн/.